

ТҮҮХ, ЭДИЙН ЗАСАГ

**МОНГОЛ, АФГАНИСТАНЫ ТҮҮХИЙН ЗАРИМ
ХОЛБОГДОЛ****М. Хурметхан**

Афганистаны нутаг нь хүн анх бий болсон бүсэд багтдаг юм. Археологийн баримтаас үзвэл одоогоос 50 мянган жилийн урьд афганистанд хүн оршин амьдрах болжээ. Энэ нутагт бүр эртнээс олон аймаг, улс угсаатан оршин тогтнож түүх, соёлоо бүтээн, I—IV зуунд тус оронд төвлөрөн байгуулагдсан Кушан гүрний дотор буддын их хөлгөн ёс дэлгэрч, утга зохиол, соёл хөгжсөн нь хөрш зэргэлдээ улс орнуудад нөлөөлж Төв Азийн бусад нүүдэлчдийн дунд хүртэл хүрчээ.

Кушаны соёл нь Юэчжи аймгийн түүхтэй хобоотой юм. Хүннү гүрэн бүрэлдэн тогтохоос өмнө Зүүн хойт Синьцзян, Ганьсу мужийн нутгаар Юэчжи хэмээх иран угсааны хүчирхэг аймгийн холбоо мандаж байв. Тэд Хүннүгийн холбоонд цохигдон Дундад Ази руу зугтахад таван аймаг нь Афганистанд очиж суурьсан юм. Юэчжи аймгийнхан орон нутгийн хүн амтай холилдон чухамдаа Кушаны соёлыг бий болгоход зонхилох үүрэг гүйцэтгэсэн түүхтэй. Юэчжи аймаг бол Хүннү-монголтой нягт холбоотой байсан юм. Энэ үеийн соёлын асар их дурсгал Афганистанд хадгалагдан үлджээ. Бамиан хотоос холгүй орших уулын элгэн хаданд ухаж гаргасан их Будда (53 м), бага Буддагийн (35 м) хөрөг бий. Кушан гүрэн цэцэглэн хөгжиж байсан үедээ хаягаа тэлж Дорнод Туркестанд нөлөөгөө тогтоов. Дорнод Туркестан Монгол нутагтай хил залгаж байсан учир кушаны соёл Монголд нөлөөлж байсан байна. Үүнийг нотлох археологийн баримт монгол нутгаас олдсон ажээ. Тэрчлэн Кушан гүрний бүрэлдэхүүнд орсон Согдоос монголчууд бичиг үсэг авч хэрэглэсэн нь бидний уйгуржин монгол гэж нэрлэдэг хуучин монгол бичиг юм.

Кушан гүрэн м.э. IV зуунд задран унасны дараа түүний нутгийн ихэнхи хэсэгт эфталитуудын ноёрхол тогтов. Эрдэмтэд эфталитууд дорно зүгээс энд нүүдлэн хүннүгээс гаралтай ард түмэн байсан гэж үздэг юм. «Византийн зохиогчид, энэтхэгийн эх сурвалжуудад эфталитуудыг Хүннү гэж үндэслэлтэй нэрлэсэн юм. Тэрчлэн хятадын судар бичигт эсгий гэрт амьдрагч нүүдэлчин ард түмэн байсан» гэж тэдний тухай бичсэн байна.¹ Эфталит гэж нэрлэж байгаа монгол нутгаас Дундад Азиар дамжин м.э. III—IV зуунд Афганистанд нүүж очсон цагаан хүннү нар билээ. Тэд афганистанд очиж амьдарч байсны ул мөр хадгалагдан үлджээ. Жишээлбэл, Дорнод Афганистанд Кунар нэртэй муж бий. Кабулын музейд цагаан хүннүгийн зоос мөнгөний дурсгал олноор хадгалагдаж байна. Кабул хотын эргэн тойронд цагаан хүннү нар дайсны довтолгооноос хамгаалах зорилгоор барьж байгуулсан өндөр хэрмийн үлдэгдэл хадгалагдаж үлдсэнийг одоо ч

¹ В. М. Массон, В. А. Ромодин. История Афганистана М., 1964. Т. I с. 200.

харж болно. Мөн м.э. VI—VIII зуунд монгол нутгаас гаралтай гэгддэг хазарууд афганистанд Волгийн адаг, Каспийн тэнгис орчмоос шилжин суурьшсан байна. Энэ тухай дараа өгүүлнэ.

Цаашид монгол-афганистаны харилцааны тухай мэдээ XIII зуунд хамаарах юм. XIII зууны эхэн үед афганистаны нутаг Чингис хааны түрэмгийлэлд өртөж Монгол гүрний ноёрхолд орсон юм. Чингисийн цэрэг эхлээд Амударьягийн хөндий, дараа нь Бамиан, Балх, Газни, Герат хотыг эзэлсэн тухай түүхэнд тэмдэглэгдсэн байдаг юм.* 1220—1332 он хүртэл Афганистаны нутаг монгол гүрний ноёрхолд байлаа. Энэ үед монгол, афганистаны хооронд харилцаа нилээд байсан байна. Монголоос афганистанд, Афганистанаас монгол нутагт хүмүүс байнга ирж очдог байжээ. Тухайлбал, тийм хүний нэг нь иран угсааны Жувейни Алад-дин Ата Малик Басаад Дин Мухаммед (1226—1283) юм. Тэр 1249—50, 1253 онуудад Монголд хоёр удаа иржээ. Монголд байхад нь түүнд монголын түүхийг судлан бичихийг даалгажээ. Тэрээр «Ертөнцийг байлдан дагуулагчийн түүх» хэмээх номыг 7 жил бичиж дуусгасан бөгөөд түүнд 1249—1253 оны монголын улс төрийн амьдралыг тусган харуулсан юм. Мөн Ираны эрдэмтэн Рашид Ад-Диний (1247—1318) «Жами Ат Таурих» («Судрын чуулган») номыг туурвихад монгол хүн оролцож байжээ. Тэр үед Афганистаны Герат хотоос Монголд ирсэн гар урчууд Хархорум хотод сууж байсан юм. Сүүлд 1239—40 онуудад 300 гаруй гэр бүлийг Монголоос Герат хотод буцааж байв. Чингис хааны үед болон дараагийн монгол хаад афганистаны нутагт монгол сайдыг томилон суулгаж, тэд орон нутгийн ард түмний зүгээс эсэргүүцэлтэй тулгарахаар Монголоос цэргийн тусламж өгдөг байсан ба тэнд байнга нутагладаг байлаа. Энэ нь одоогийн афганистаны болон Ираны дорнод хэсгийн хүн амын угсаатны бүрэгт ул мөрөө үлдээсэн байна. Афганистаны хүн амын ихэнх нь дари, пушту хэлээр ярилцдаг афган үндэстнээс гадна тажиг, түрэг, хазар-монгол зэрэг угсаатан, ястан оршин сууж байна.

Афганистанд байгаа монгол гаралтай угсаатанд «чар» аймаг (дөрвөн аймаг) хазар, могол (монгол) зэрэг ястан хамрагдана.

1. Монгол гаралтай гэж тооцогддог Афганистан дахь угсаатны нэг нь Чар аймаг юм. Тэдний бүрэлдэхүүнд таймены, хазар-аймаг, теймур, зур овог орно. Чар аймгийнхан монголжуу царайтай бөгөөд тэдний нилээд хэсэг нь гарал үүслээрээ монгол болохыг олон эрдэмтэд тэмдэглэсэн байдаг юм.² Чар аймгийнхан голдуу баруун Афганистан, Дорнод Иранд оршин суудаг билээ. Чар аймгийн нэг том хэсгийг бас

* Өнгөрсөн зууны эцсээр Дж. Харлан зэрэг эрдэмтэд хазаруудын монголжуу царайтайг тэмдэглээд монгол түрэг холимог гарал үүсэлтэй гэсэн онол дэвшүүлжээ. Мөн М. Эльфинстон, А. Берис, Г. Вамбери зэрэг эрдэмтэд хазаруудыг цэвэр монгол гаралтай гэж үзсэн байна. Хазаруудын түүхийг судалсан, орос, зөвлөлтийн эрдэмтэд ч гэсэн тэдний монголжуу царайтай, монгол гаралтай болохыг тэмдэглэсэн байна. Тухайлбал, зөвлөлтийн эрдэмтэн В. А. Ромодин хазаруудын гарал үүслийг тодорхойлж бичихдээ: «Народность эта монгольского или точнее, тюрко-монгольского проис-хождения» гэжээ. В. М. Массон. В. А. Ромодин, История Афганистана М., 1964., т. I. с. 289, «»

* Татаро - Монголы в Азии и Европе. М., 1977. 140—150-р тал. «История Афганистана». М., 1981. с. 80—93, В. М. Массон, В. А. Ромодин. История Афганистана. т. I., с. 277—305 зэргийг үзнэ үү.

² Klimburg. Afganstan-Vien, 1962. p. 132.

Рашидов Р. Т. Аймаки Автореферат канд дисс. Ташкент, 1970, с. 7.

хазар аймаг гэж нэрлэнэ. Гэвч энэ аймаг хазаараас ялгаатай юм. Хазар-аймаг угсаатныг Дей-зейнат, Калайноугийн хазар гэж бас нэрлэдэг. Тэд Кашан-Гармак голын хөндий Калай-оугийн баян бүрд газраар оршин амьдардаг юм. Хазар аймгийнхан дари хэлээр ярьж, лалын шашны суннит ёсыг шүтэн Чар аймаг угсаатан бүрэлдэн тогтох явц XIII зуунаас хойш явагджээ. Өөрөөр хэлбэл тэд Чингис болон түүний дараах монгол хаадын цэргийн үлдмэр бололтой юм.

2. Афганистанд гарал үүслийн хувьд монгол угсаатны гэж тооцогддог* хүн хүн амын тоогоор олон нь хазарууд юм. Одоо хазарууд Хазаржат гэж нэрлэгдэх Төв Афганистан болон Кандагар, Герат, Газни, Кабул муж, Кабул хотод амьдардаг юм. Хазаруудын эртний түүх судлагдаагүй бөгөөд Доголон Төмөр Никударын ордыг эзлэн тэдний ихэнх хэсгийг Төв Афганистанд шилжүүлэн суулгав. Энэ нь хазарын ард түмэн бүрэлдэн тогтоход чухал үүрэг гүйцэтгэсэн хийгээд тэдний XVII зуунаас хойшхи түүх нь нилээд тодорхой юм³.

Олон эрдэмтэд хазаруудын гарал үүслийг Чингисийн цэргийн үлдмэр гэж үзэх боловч Төв афганистанд Чингис монгол цэрэг үлдээсэн тухай баримт алга билээ. Өөр хэсэг эрдэмтэд хазарын гарал үүслийг Мөнх хааны (1248--1256) болон Хүлэгү хааны (1256--1265) цэргийн үлдэгдэлтэй холбож байна. Бас зарим эрдэмтэд хазаруудыг монгол-түрэг холимог гаралтай гэж үздэг явдал бий. Эдгээр эрдэмтдийн саналд нэгэн зүйлийг, тухайлбал, тэд цөм хазарууд монгол гаралтай болохыг ямар нэг хэмжээгээр хүлээн зөвшөөрч байгааг тэмдэглэвэл зохино. Зөвхөн тэд афганистанд чухам хэдийд очиж нутагласан талаар санал зөрөөтэй байгаа нь харагдаж байна. Гэтэл судалгааны сүүлийн үеийн материалууд Чингисийн түрэмгийллээс өмнө Афганистанд хазарууд нутаглаж байсныг нотолж байна. Үүнийг Афганистаны зарим эрдэмтэд хазарууд бол тус нутгийн уугуул ард түмэн юм. Тэд афганистанд Александр Македонскийн эзлэлтээс өмнө оршин сууж байсан гэж үзэж байна.⁴ Энэ саналд хазарууд энэ нутагт нилээд дээр үеэс оршин сууж буйг тэмдэглэсэн боловч хазарууд Александр Македонскийн үед Афганистанд арай шилжин суурьшаагүй байсан юм. Өөрөөр хэлбэл тэд Афганистанд Александр Македонскийн эзлэлтээс өмнө ч биш, XIII зууны үед ч биш, VI—VIII зуунаас оршин суух болсон юм гэсэн санал дэвшүүлж байна. Хазар, цагаан хазар нар VI—VII зуунд Монгол нутгаас Дундад Ази руу нүүдэлснийг зарим эрдэмтэд⁵ тэмдэглэсэн нь ингэж үзэх үндэстэй болгож байна. Өөрөөр хэлбэл тэд Волгийн адаг, Каспийн тэнгис орчмоос Афганистанд шилжин суурьшсан байна. Нөгөө талаар хазар гэсэн үгийн гарлыг перс хэлний «хазара» (мянга) гэсэн үгтэй холбон тайлбарладаг. Гэтэл хазар гэдэг нэр XIII зуунд бий болсон биш, м.э. III—IV зуунаас тодорхой байсан байна. Иймээс «хазар» гэсэн үгийн гарал үүсэл перс хэлний «хазара» гэсэн үгтэй холбоогүй юм. Тус нэртэй монгол нутагт 750 онд босгосон Тэрхийн гэрэлт хөшөөний 3-р нүүрний 17-р мөрөнд гардаг **qadar, qasar** гэсэн⁶ аймгийн нэр холбоотой байж болох юм. VI—VII зуунд монгол нутгаас нүүсэн хазар, цагаан хазар, одоогийн хазар үндэстэн бүрэлдэн тогтох цөм нь болж сүүлд янз бүрийн үед очсон монголчууд хэл яриа, зан заншил ойролцоо хазаруудтай ойртон ижилссэн бололтой юм. Хазарууд монгол гаралтай болохыг нотлох бусад баримтууд ч хангалттай бий. Үүнээс заримыг дурдвал XVI зуунд Афганистан, Пакистан, Энэтхэг зэрэгт ноёрхлоо тогтоож бай-

³ Темирханов. Л. Хазарайцы. т. 1974.

⁴ Хабиби Абұлхай. Айа-и хазара калима-и кадимтар аст. «Ариана» 1968, № 8.

⁵ J. A. Tom CCL. James Hamilton 1962. 34-46.

⁶ С. Т. Кляшторный «Советская тюркология» Баку. 1980, № 3, 81-96.

сан Бабур хаан «Бабурын тэмдэглэл» хэмээх номондоо XVI зуунд хазарууд монгол хэлээр ярилцаж байсныг тэмдэглэсэн байдаг.⁷ Нөгөө талаар хазарууд зүс царай, антропологийн хувьд монгол хүнтэй адил, аж төрөх ёсонд төстэй зүйл цөөнгүй юм. Хазарууд Хазарги хэлээр ярилцана. Хазарги хэлний үгсийн сангийн 10 орчим хувь нь монгол үг байдгийг Дж. Даллинга зэрэг эрдэмтэд нотолсон байдаг юм.⁸ Ж: **hurud** (хурууд), **aaba** (аав), **abagha** (авга ах), **adali** (адил), **era** (эр), **es** (эс, үгүй), **ayka** (эхээ), **egachi** (эгч), **bayo** (баян), **tolagha** (толгой), **taala** (тал газар) **jaagaa** (дээлийн зах), **jergafu** (зоригт), **gamfu** (ихэр хамт), **qudaghu** (бэр, хүргэний эх), **qubau** (бэр, хүргэний эцэг) г. м. олон зуун үгийг жагсааж болох юм. Нөгөө талаар монгол хэлнээс дари, пушту хэлэнд орсон үг олон бий. Ж: гаруж (гарц), хабирга (хавирга), айла (айл), улус (улс), курт (хурууд), кешикчиен (хишигтэн) г. м. үг бий. Мөн Афганистаны газар усны нэрэнд монгол үг элбэг байдаг ажээ.

3.Гарал үүсэл хэл ярианы хувьд маргаангүй монголчууд Афганистанд бас байдаг байна.* Одоо тэд Афганистаны баруун болон зүүн хэсэгт оршин суудаг ажээ. Тэд гарлынхаа хувьд нэлээд сүүлийн үед Афганистанд очсон монголчууд тухайлбал, доголон Төмөрийн ач хүү Бабур хааны албат монголчуудын үлдмэр байж болох юм. Бабурын зуслангийн хот, хэрмийн үлдэгдэл, мөргөлийн сүм урлан хийсэн өнгө бүрийн гантиг, бурхан сэлт нь Кабулд хадгалагдан үлджээ. Бидэнд тодорхой баттай мэдээгээр Гур мужид 200, Герат мужид 100, Майманад 300, Сари Пулийн районд 600, Кундуз, Баглан мужид 2000 монгол өрх амьдарч байна. Өөрөөр хэлбэл Афганистанд байгаа монголчуудын нийт тоо 16—18 мянга,⁹ заримдаа 40 мянга байдаг гэсэн мэдээ бий. Эдгээр хүмүүс дундад эртний монгол хэлтэйгээ байна. Тэд өөрсдийнхөө үр хүүхдэд эх хэлээ сургахын тулд янз бүрийн толь бичиг зохиож, ном судар монгол хэлэнд орчуулж байсан нь хадгалагджээ. Тэрчлэн Кабулын үндэсний музейд одоогоор шинжлэх ухаанд утга учир нь үл тайлагдсан уйгуржин монгол бичгээр бичигдсэн нэгэн ном хадгалагдаж байна. Эдгээр монголчууд ахуй амьдралдаа тухайн үеийн зан заншлын олон зүйлийг хадгалж байгаа юм. Афганистанд байдаг монголчуудын тухай гадаадын олон эрдэмтэд тэдний түүх, соёл, хэлийг судалсан байна. Афганистан дахь монголчуудын тухай анхны судалгаа 1838 онд хэвлэгджээ. Түүнээс хойш тэдний талаар судалгааны нилээд олон бүтээл гарчээ. Үүнд Шурман (АНУ Микаэль Вайерс, Хайссиг (ХБНГУ), К. Э. Раулинг (Канад) С. Хуммом (Афганистан), Ивамура (Япон), Рамстедт (Финляндия), Легети (Унгар) зэрэг хүмүүсийн бүтээлийг дурдаж болно. Гэхдээ дари хэлээр монголын түүх, монгол-афганистаны эртний харилцаанд холбогдох материал бүхий ном зохиолууд системтэй судлагдаагүй хэвээр байна.

⁷ «Записи Бабура» Ташкент. 1958. с. 155

⁸ Лич Р. Словарь языка монгольских аймаков. Журн. «Королевства азиатского общества Бенгалии» № 7. Калькутта. 1838. с. 735—787. -Thesuger W. The Hazaras of central Afganstan. "The ceographical journal" 1955 Vol CXXI, pt—3, с. 313, 109.

*Афганистан дахь монголчуудын талаар нэлээд судалгаа явуулсан Афганистаны эрдэмтэн Поханд Сандсултаншо Хуммом энэ талаар бичихдээ: «Афганистанд монголчуудын овог аймаг одоо хүртэл амьдарч байна. Тэдгээрийн ихэнх нь Герат, Гур хотуудад суудаг бөгөөд өөрийн төрөлх монгол хэлээр ярилцдаг гэж тэмдэглэжээ. «Материалы докладов межвузовской научно-методической конференции. 10—13 ноября 1982 г. Тезисы докладов. Кабул—1982. Поханд Саидсултаншо Хуммом, «Этнография монголов» с. 19.

⁹ Кисляков В. Н. Хазарейцы аймаки, монголы «Советская этнография» 1973, No 4., с. 135.

Schurmann, H. F., The Mongols of Afganstan, Hague, Mouton. 1961.

Тэрчлэн нилээд сүүлийн үед XVIII—XIX зуунд Афганистанд янз бүрийн шалтгаанаар монголчууд очиж амьдарч байв. Тухайлбал, Зүүнгарын хаант улс мөхсөний дараа хэсэг монголчууд Афганистанд очиж Төмөр шагын (1773--1793) дэргэд алба хааж байсан зэрэг болно.

Иймд Афганистанд оршин суудаг монголчуудын түүх, хэл, угсаатны зүйн талаар манай эрдэмтэд гүнзгийрүүлэн судалбал монгол судлалд чухал нэмэр болох юм. Түүнчлэн Афганистанд байгаа монгол угсааны гэж үзэж буй Чар аймаг, хазарын тухайд мөн судалгаа явуулбал сонирхолтой юм.

МОНГОЛО-АФГАНСКИЕ ИСТОРИЧЕСКИЕ СВЯЗИ (Резюме)

М. Хурметхан

Существовавшее на территории Средней Азии, Кушанское государство, достигнув своего расцвета в I— IV вв. н. э. установило господство над Восточным Туркестаном и оказывало влияние на соседние с ним монгольские племена. О проникновении кушанской культуры в древнюю Монголию достаточно красноречиво говорят многочисленные археологические находки, а также тот факт, что бывшие в составе Кушанской империи согдосские монголы переняли у кушан алфавит, который лег в основу старомонгольской письменности.

После падения Кушанской империи на большей части ее территории установили господство эфталиты, которые, по мнению многих ученых-историков, пришли с Востока и являлись народом, родственником хунну.

Дальнейшие сведения о монголо-афганских связях относятся к XIII в. С установлением монгольского господства над Афганистаном происходит переселение отдельных этнических групп из Монголии в Афганистан и обратно. Кроме того для подавления сопротивления местного населения в Афганистане действовал постоянный монгольский военный корпус, часть служащих которого впоследствии ассимилировалась с племенами и народами Восточного Ирана и Афганистана.

Многие ученые отмечают монгольское происхождение, живущих в Афганистане хазаров, монголов и племени «чор». В статье приводятся некоторые факты и доказательства Монгольского происхождения хазаров и выдвигается предположение об их переселении в Афганистан в VI—VIII вв.

Далее, автор считает, что название племени хазар не происходит, как принято считать, от персидского «хазара» (тысяча), а основываясь на тексте Орхон-Енисейских каменных надписях, относит название «хазара» III—IV вв.

В заключение в статье приводятся обзор трудов ученых, исследовавших этнический состав, язык, культуру выходцев из моголов (монгол) живущих в Афганистане.

Изучение истории, языка, этнографии монголов, хазаров и чор, безусловно, будет иметь особое значение в изучении исторических связей Монголии и Афганистана.